

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

“СЭЛЭНГЭ АЗЗА ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЙЛ АЖИЛЛАГАА”

Тус компанийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд оршиж буй
алдаа, зөрчлийг засаж, залруулах шаардлагатай байна.

Сүхбаатар сум 2018 он

Тайланг бэлтгэсэн:
Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын газар

**Дарга, тэргүүлэх
аудитор**
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Аудитор
Б.Эрдэнэзул
Ц.Уртнасан

2018 оны 09 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70362442
дугаарын утас, 70363040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ аймаг,
Сүхбаатар сум, аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Үйл ажиллагааны орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?

- 1.1. Үйл ажиллагааны орлогыг бодитоор төлөвлөн, бүрэн төвлөрүүлж байна уу?
- 1.2. Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг батлагдсан төлөвлөгөөний дагуу үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу?
- 1.3. Авлага, өр төлбөрийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байна уу?

2. Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

- 2.1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу?
- 2.2. Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу?
- 2.3. Хөрөнгийг бүртгэл, тайланд иж бүрэн тусгаж, тооллого тооцоог хугацаанд нь гүйцэтгэж байна уу?

3. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөө бүхий дотоод хяналт хийгдэж байна уу?

- 3.1. Санхүүгийн тайлан, гүйцэтгэл, үр дүнг ТУЗ-өөр хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгч байна уу?
- 3.2. Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу?

Илрүүлсэн зөрчил

Аудитын дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АЗЗА	Авто замын засвар, арчлалт
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.1. Аудит хийсэн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн зарим үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

1. Үйл ажиллагааны орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөн, үр ашигтай ажиллаж байна уу?
2. Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?
3. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөө бүхий дотоод хяналт хийгдэж байна уу?

Аудитад Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн 2017 оны санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг хамруулсан болно.

1.3 Аудитын арга зүй

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, Гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан тус компанийн гүйцэтгэх захирал, нягтлан бодогчид, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга аван, компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Дараах хууль эрхийн актуудыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Компанийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Татварын багц хуулиуд,
- Нийгмийн даатгалын багц хуулиуд,
- Дээрх хуулиудтай нийцүүлэн холбогдох байгууллагуудаас гаргасан дүрэм, журам, бусад эрх зүйн актууд.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор Б.Эрдэнэзул, Ц.Уртнасан нар 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

1.5 Ерөнхий мэдээлэл

Төрийн өмчийн хорооны 2012 оны 274 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн дүрэм”-ийн 2.1-д “Компанийн үндсэн зорилт нь төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг төрийн захиргааны байгууллагатай байгуулсан “Зам засвар, арчлалтын гэрээ”-ний дагуу Сэлэнгэ аймгийн хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино.” гэж тодорхойлсон байна.

Тус компани нь анх 1933 онд Зам анги нэртэйгээр байгуулагдсан бөгөөд өнөөг хүртэл 5 удаагийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгджээ. Үүнд:

- 1981 онд Зам барилга, засвар, арчлалтын контор,
- 1991 онд Сэлэнгэ аймаг дахь Зам засвар арчлалтын УУГ,
- 1995 онд Сэлэнгэ авто зам засвар, арчлалтын орон нутгийн өмчит компани,
- 2003 онд төрийн өмчит УБ-АЗЗАН ХК-ийн Сэлэнгэ салбар,
- 2006 оны 8 дугаар сараас эхлэн Сэлэнгэ АЗЗА ТӨХК болжээ.

Сэлэнгэ АЗЗА ТӨХК нь 52 ажиллагсадтайгаар, жилдээ 1.5-2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий зам барилга, замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Бүлэг 1

Үйл ажиллагааны орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөн, үр ашигтай ажиллаж байна уу

Үйл ажиллагааны орлого, зарлагыг бодит байдалд үндэслэж, үнэн зөв төлөвлөөгүй байна.

Оршил

Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 06 дугаар тогтоолоор тайлант онд 1,500,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,446,711.2 мянган төгрөгийн зарлага гарган, 47,959.9 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллах бизнес төлөвлөгөөг баталснаас орлого 36.8 хувиар буюу 551,316.4 мянган төгрөгөөр давж, зарлага 20.3 хувиар буюу 484,404.3 мянган төгрөгөөр хэтрэн, 106,847.2 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1.

д/д	Үзүүлэлт	Бизнес төлөвлөгөө /НӨАТ-гүй/ /мян.төг/	Гүйцэтгэл /НӨАТ-гүй/		Зөрүү дүн /мян.төг/
			Дүнгээр /мян.төг/	Хувиар	
1	Нийт орлого	1,500,000.0	2,051,316.4	136.8	551,316.4
	Үүнээс: Улсын чанартай зам засвар арчлалт	730,000.0	720,510.0	98.7	-9,490.0
	Орон нутгийн чанартай зам засварын ажил	770,000.0	1,215,319.9	157.8	445,319.9
	Бүтээгдэхүүн борлуулалт, тоног төхөөрөмжийн түрээс		105,329.2		105,329.2

	Үйл ажиллагааны бус орлого		10,157.3		10,157.3
2	Нийт зардал	1,446,711.2	1,931,115.5	133.5	484,404.3
	Үүнээс: ББӨ	1,266,711.2	1,740,146.3	137.4	473,435.1
	Удирдлагын зардал	180,000.0	177,633.0	98.7	-2,367.0
	Бусад зардал		13,336.2		13,336.2
3	Үйл ажиллагааны ашиг	53,288.8	120,200.9	225.6	66,912.1
4	Орлогын татвар	5,328.9	13,353.1	250.6	8,024.2
5	Жилийн цэвэр ашиг	47,959.9	106,847.8	222.8	58,887.9

1.1 Тайлант оны үйл ажиллагааны орлогыг бүртгэл, тайланд дутуу тусгасан байна.

Сэлэнгэ АЗЗА ТӨХК нь Компанийн дүрэмд заасан үндсэн 3 чиглэлийн¹ хүрээнд үйл ажиллагаа явуулж, орлого бүрдүүлсэн бөгөөд шинээр бизнесийн үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Тайлант онд орон нутгийн чанартай зам засварын ажлын орлого 445,319.9 мянган төгрөгөөр давж биелсэн бол улсын чанартай зам засвар, арчлалтын санхүүжилт 9,490.0 мянган төгрөгөөр дутуу олгогдсон байна.

Харин жил бүр тодорхой хэмжээгээр төвлөрдөг бүтээгдэхүүн борлуулалтын, тоног төхөөрөмж түрээслүүлсний болон бусад орлогыг урьдчилан тооцож, төлөвлөөгүйгээс 115,486.5 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй орлогын гүйцэтгэлтэй тайлагнагджээ. Үүнд:

- Бэлэн бүтээгдэхүүн борлуулалтын 97,444.0 мянган төгрөгийн,
- Тоног төхөөрөмжийн түрээсийн 11,236.7 мянган төгрөгийн,
- Банкны хүүгийн орлогын 4,185.4 мянган төгрөгийн,
- Бусад 2,620.4 мянган төгрөгийн.

Өөрөөр хэлбэл жил бүр тодорхой хэмжээгээр төвлөрдөг дээрх орлогуудыг тайлант оны орлогын төлөвлөгөөнд огт тооцож, тусгаагүй, нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглаж төлөвлөөгүй байна.

Тайлант онд борлуулалтын орлогыг 72,742.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

2017 онд зам засвар, арчлалт, бүтээгдэхүүн борлуулалтын болон бусад үйл ажиллагаанаас нийт 2,417,908.9 мянган төгрөгийн орлого төвлөрсөн бөгөөд 2 ажлын 13,485.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэлд огт тусгаагүй, 1 ажлын 59,257.6 мянган төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан байсныг 2018 оны орлогод нөхөн тусгасан байна. Үүнд:

- УБТЗ нийгэмлэгийн Барилга ашиглалт, үйлчилгээний 2-р ангитай байгуулсан гэрээний дагуу 5,485.0 мянган төгрөгийн өртөг бүхий 32 айлын орон сууцны гаднах асфальтан замыг сэргээх ажлыг гүйцэтгэж, комиссын актаар хүлээлгэн өгсөн ч орлогод тусгаагүй, авлага үүсгээгүй,

¹ Компанийн дүрмийн 2.2 Компани нь энэхүү дүрэмд заасан зорилтоо хэрэгжүүлэх зорилгоор дор дурдсан үндсэн үйл ажиллагаа эрхэлнэ: 2.2.1 Компани нь улсын чанартай авто замын засвар арчлалт, шугамын хэсгүүдийг шуурхай удирдлагаар хангаж хариуцсан авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, гарсан эвдрэл, гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх. 2.2.2 Компани нь замын барилгын үйлдвэрлэл эрхэлж, тоног төхөөрөмж, машин механизмыг үр ашигтай ажиллуулах. 2.2.3 Компани нь авто замын засвар, арчлалтын үйл ажиллагааг гүйцэтгэхдээ холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан авто замын урт, тэдгээрийн дагуу байрлах шугаман албадын байршил, засвар, арчлалтын ажлын нэгж, норм норматив, төсвийн норм, үнэлгээ болон түрээсийн тоног төхөөрөмжийн машин цагийн норм үнэлгээг мөрдөж ажиллах.

- Цагааннуур сумын Засаг даргын орлогчтой байгуулсан 8,000.0 мянган төгрөгийн хогийн нээгдсэн цэгийн хог хаягдлыг цэвэрлэх ажлын хөлсийг хайргаар төлж барагдуулсныг орлогод тусгаагүй, бараа материалын тайланд орлого авч зарцуулаагүй,
- Сэлэнгэ аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу 231,113.2 мянган төгрөгийн Сүхбаатар сумын Партизаны талбайн зам, авто зогсоол байгуулах ажлын санхүүжилтээс 109,514.9 мянган төгрөгийг цементээр олгосноос 59,257.6 мянган төгрөгийн орлогыг бүртгэлд дутуу тусгасан байна.

Хүснэгт 2

Тайлант онд төвлөрүүлсэн орлого

/мян.төг. НӨАТ оруулсан дүнгээр/

д/ д	Орлогын нэр төрөл	Санхүүгийн тайлангаар орлогын дүн		Анхан шатны баримттай тулгасан орлогын дүн		Илүү /-/ дутуу /+/ тусгасан	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зам тээврийн хөгжлийн яамтай байгуулсан гэрээний дагуу	5	792,561.0	5	792,561.0	-	-
2	Сэлэнгэ аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу	9	469,169.6	9	528,427.2	1	59,257.6
3	Дархан-Уул аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу	1	753,014.0	1	753,014.0	-	-
4	Сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээний дагуу	5	105,197.7	6	113,197.7	1	8,000.0
5	Бусад байгууллагатай байгуулсан гэрээний дагуу	5	17,918.3	6	23,403.3	1	5,485.0
6	Хайрга, дайргын борлуулалтын орлого	1	147,615.8	1	147,615.8	-	-
7	Цементийн борлуулалт	1	35,675.5	1	35,675.5	-	-
8	Тоног төхөөрөмжийн түрээсийн орлого	1	11,236.7	1	11,236.7	-	-
9	Эрчмийн тооллогын санхүүжилт	1	2,420.4	1	2,420.4	-	-
10	Хүүгийн орлого	1	4,185.4	1	4,185.4		
11	Бусад орлого	2	6,171.9	2	6,171.9	-	-
Нийт дүн		32	2,345,166.3	34	2,417,908.9	3	72,742.6

Борлуулалтын журнал хөтөлж хэвшээгүй байна.

Борлуулалтын журнал нь тооцоо үүсгэн борлуулсан бараа, бүтээгдэхүүн болон гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээний орлогыг ойлгомжтой, тодорхой байдлаар илэрхийлэх, борлуулалтын орлогыг бусад орлогоос ялган, салгаж бүртгэх, тайлагнах ач холбогдолтой байдаг. Гэвч тус компани нь борлуулалтын журнал хөтөлж хэвшээгүй нь хэрэгжсэн орлогын гүйлгээг бүртгэл тайланд огт тусгахгүй буюу дутуу тусгах нөхцөлийг бүрдүүлж байна.

1.2 Зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, тайлант жилийн явцад ТУЗ-өөр хэлэлцүүлэн, тодотгож батлуулаагүй зэргээс шалтгаалан төлөвлөсөн зардал 33.5 хувиар хэтэрсэн байна.

2017 онд 15 төрлийн зардалд 1,446,711.2 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан ч гүйцэтгэлээр 29 төрлийн зардалд 1,931,115.5 мянган төгрөгийг зарцуулж, зардлыг 33.5 хувиар буюу 484,404.3 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Зардлын нэр төрөл	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Хэтрэлт, (хэмнэлт)	
				Мян төг	%
1	Шуудан холбоо	2,749.2	3,746.9	997.7	36.3
2	Ажилчдын цалин	334,128.0	382,709.1	48,581.1	14.5
3	НДШимтгэл	43,436.6	48,812.4	5,375.8	12.4
4	Хангамжийн материал	498,817.4	553,284.5	54,467.1	10.9
5	Баяр ёслолын хүлээн авалт	12,832.6	13,336.2	503.6	3.9
6	Шатахуун /км/	287,888.1	281,153.8	(6,734.2)	-2.3
7	ТУЗ-ын зардал	33,603.2	29,077.2	(4,526.0)	-13.5
8	Шатах тослох материал	54,363.6	44,700.1	(9,663.5)	-17.8
9	Сэлбэг хэрэгсэл	101,630.0	69,887.8	(31,742.2)	-31.2
10	Хөдөлмөр хамгаалал	24,720.0	16,086.1	(8,633.9)	-34.9
11	Түлээ нүүрс	4,500.0	2,552.3	(1,947.7)	-43.3
12	Томилолт	16,368.8	7,597.1	(8,771.8)	-53.6
13	Бичиг хэрэг	5,251.4	1,510.8	(3,740.6)	-71.2
14	Сургалт	19,222.3	1,645.6	(17,576.8)	-91.4
15	Ногдол ашиг	7,200.0		(7,200.0)	-
16	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	-	147,580.3	147,580.3	100.0
17	Элэгдлийн зардал	-	141,965.4	141,965.4	
18	Тээврийн зардал	-	78,712.4	78,712.4	
19	Хээрийн нэмэгдэл, хоол	-	40,820.3	40,820.3	
20	Үйлчилгээний зардал	-	26,211.9	26,211.9	
21	Ашиглалтын зардал	-	21,323.1	21,323.1	
22	Онц оролтын 10% / мал амьтад /	-	4,769.2	4,769.2	
23	Аудитын зардал	-	3,000.0	3,000.0	
24	Татварын зардал авто тээврийн хэрэгсэл	-	2,914.6	2,914.6	
25	Бусад зардал	-	2,436.4	2,436.4	
26	Даатгалын зардал	-	2,015.5	2,015.5	
27	Түрээсийн зардал	-	1,882.6	1,882.6	
28	Гамшиг	-	910.0	910.0	
29	Сувиллын зардал	-	473.8	473.8	
Нийт дүн		1,446,711.2	1,931,115.5	484,404.3	33.5

Төлөвлөсөн 15 төрлийн зардлаас ногдол ашгийн зардал нь 2016 онд алдагдалтай ажилласнаас хуваарилагдаагүй бол 9 төрлийн зардал 2.3-91.4 хувиар буюу 100,536.6 мянган төгрөгөөр хэмнэгджээ.

Харин 5 төрлийн зардал 3.9-36.3 хувиар хэтэрсэн бол төлөвлөгөөнд тусгагдаагүй 14 төрлийн зардалд 584,940.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Төлөвлөгдөөгүй болон хэтэрсэн зардлын шалтгааныг судлахад бодитоор төлөвлөөгүйгээс төлөвлөгөөнд тусгаагүй 10 төрлийн 297,877.0 мянган төгрөгийн зайлшгүй зардал, батлагдсан төлөвлөгөөг мөрдөөгүйгээс хэмнэж болох 3 төрлийн 149,081.6 мянган төгрөгийн зардал гарсан бол урьдчилан тооцох боломжгүй зайлшгүй нөхцөл байдлын улмаас 6 төрлийн 137,982.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

Бодит гүйцэтгэлээр зайлшгүй гарах байсан ч төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын 141,965.4 мянган төгрөг,

- *Хайрга, дайрга, асфальтыг гэрээний дагуу тээвэрлэх тээврийн зардлын 78,712.4 мянган төгрөг,*
- *Ажиллагсдын хээрийн нэмэгдлийн болон өдрийн хоолны зардлын 40,820.3 мянган төгрөг,*
- *Гэрэл цахилгаан, цэвэр бохир ус зэрэг тогтмол зардлын 21,323.1 мянган төгрөг,*
- *Малын тэжээл, эм тарианы зардлын 4,769.2 мянган төгрөг,*
- *Санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөрийн 3,000.0 мянган төгрөг,*
- *Авто тээрийн болон өөрөө явагч хэрэгслийн, үл хөдлөх хөрөнгийн гэх мэт албан татварын зардлын 2,914.6 мянган төгрөг,*
- *Тээврийн хэрэгслийн даатгалын зардлын 2,015.5 мянган төгрөг,*
- *Авто машины гаж түрээсэлсний 1,882.6 мянган төгрөг,*
- *Амралт сувиллын буюу нэг удаагийн тэтгэмжийн зардлын 473.8 мянган төгрөг зэрэг болно.*

Батлагдсан зардлын төлөвлөгөөг мөрдөж ажиллаагүйгээс хэтэрсэн болон хэмнэж болох байсан зардал:

- *ТУЗ-ийн шийдвэргүйгээр Дархан-Уул аймагт гүйцэтгэсэн 1.38 км зам, гүүрний ажилд туслан гүйцэтгэгч авч ажиллуулсан ажлын зардал 147,580.3 мянган төгрөг /НӨАТ-гүйгээр /*
- *Шуудан холбооны зардлыг 997.7 мянган төгрөгөөр, баяр ёслол хүлээн авалтын зардлыг 503.6 мянган төгрөгөөр төлөвлөгөөнөөс хэтрүүлсэн зэрэг болно.*

Урьдчилан тооцоолох боломжгүй, зайлшгүй нөхцөл байдлын улмаас үүссэн зардал:

- *Гамшиг ослын үеийн зардал 910.0 мянган төгрөг,*
- *Банкны үйлчилгээний хураамж болон тендерийн материал боловсруулах зэрэг зардлын 2,436.4 мянган төгрөг,*
- *Үйл ажиллагаатай холбоотойгоор засвар үйлчилгээ хийлгэх болон бусад зардлын 26,211.9 мянган төгрөг,*
- *Тайлант хугацаанд зам засвар, арчлалтын ажил нэмж хийсэнтэй холбоотойгоор цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 53,956.9 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардал 54,467.1 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.*

Дээрх байдлаас үзэхэд тус компани нь үйл ажиллагааны орлого, зарлагыг бодит байдалд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүй бөгөөд төрийн өмчит хувьцаат компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх чухал баримт бичиг болох “ Бизнес төлөвлөгөө”-г үндэслэлгүйгээр боловсруулсан байна.

Анхан шатны баримтын бүрдэлгүй болон бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан зөрчил нийтлэг байдлаар оршиж байна.

2017 оны санхүүгийн тайланд тусгагдсан зарлагын гүйлгээг анхан шатны баримт, материалтай тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Зориулалт тодорхойгүй, анхан шатны ямар ч баримтгүй дараах зардлуудад 2,693.2 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд:

- *Солонго инвест ХХК-иас анхан шатны баримтгүйгээр 148.0 мянган төгрөгийн архи худалдан авсан,*
- *Анхан шатны баримтгүйгээр 39.4 мянган төгрөгийг шатахууны зардалд, 12.0 мянган төгрөгийг цэцэг авахад, 134.5 мянган төгрөгийг хүмүүс хооллоход зарцуулсан,*

- *Томилолтын үнэмлэх, дагалдах баримтгүйгээр 1,478.0 мянган төгрөгийг 9 ажилтанд олгосон,*
 - *Албан томилолтын зардлыг илүү бодож 301.5 мянган төгрөг олгосон,*
 - *Иргэн Х.Ариунжаргал тус компаниас асфальт бетон хольц, дайрга авахаар урьдчилгаа 79,643.8 мянган төгрөг шилжүүлснийг бүтээгдэхүүн нийлүүлээгүй тул буцаан шилжүүлэхдээ 579.8 мянган төгрөг илүү шилжүүлсэн байна.*
2. Харилцах болон кассаас нэхэмжлэх, бэлэн мөнгө хүссэн өргөдөлгүйгээр нийт 35,392.4 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийсэн нь тодорхойгүй авлага үүсгэх, мөнгөн хөрөнгө шамшигдах эрсдэлийг үүсгэж байна.
 3. Гэрээгээр болон аман тохиролцоогоор хийлгэсэн ажил үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэж, актаар хүлээн авалгүйгээр 9,136.7 мянган төгрөгийн зардал гаргасан нь тухайн ажил, үйлчилгээ бодитой, чанартай хийгдсэн эсэхийг нотолж чадахгүй байна.
 4. Харилцагч байгууллагуудтай үүссэн төлбөр, тооцоог кассаас барагдуулахдаа харилцагч байгууллагаас бэлэн мөнгө хүлээж авсныг нотлох бэлэн мөнгөний орлогын ордер авалгүйгээр 31,414.5 мянган төгрөг олгосон байгаа нь бэлэн мөнгөний зарцуулалтыг бүрэн нотолж чадахгүй байна.
 5. Харилцагч байгууллагын төлбөр, тооцоог гүйцэтгэхдээ байгуулсан гэрээ, зарлагын баримт зэрэг анхан шатны баримт дахь харилцагчийн нэрийг зөрүүтэйгээр бичиж, нийт 19,075.7 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүнд:
 - *Тооцоо нийлсэн актаар баталгаажуулж Эн Си Эс Жи ХХК-ийн урьд оны өглөг 8,174.9 мянган төгрөгийг н.Болорсар, С.Дашзэвэг гэсэн хувь хүний данс руу шилжүүлсэн байна,*
 - *Мегалайн ХХК-тай байгуулсан гэрээний дагуу нийлүүлэгдсэн битумын төлбөрийг уг компанийн дансанд бус Туул гэсэн хувь хүний данс руу шилжүүлсэн,*
 - *Худалдан авсан бараа материалын тооцоог кассаас гүйцэтгэхдээ нэр зөрүүлэн 10,900.8 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.*
 6. Кассаас анхан шатны баримтгүйгээр шатахуун, сургалт, замын ажлын гүйцэтгэлийн зураг зэрэг зардлуудад нийт 2,454.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

1.3 Харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж хэвшээгүй бөгөөд зайлшгүй шаардлага үүсээгүй байхад шинээр авлага, өр төлбөр үүсгэсэн байна.

Сэлэнгэ-АЗЗА ТӨХК нь 2017 оны жилийн эцэст нийт 166,553.5 мянган төгрөгийн авлага, 245,158.8 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөр, 325,147.9 мянган төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Авлагын талаар:

Авлагыг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж үзэхэд 63,618.3 мянган төгрөгөөр буюу 27.6 хувиар буурсан бөгөөд байгууллагаас авах авлага, НӨАТ-ын авлага, ажиллагсадтай үүссэн хоолны тооцооны авлага буурч, хүмүүсээс авах авлага, ажиллагсадтай үүссэн цалингийн урьдчилгааны авлага нэмэгдсэн байна. Авлагын өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4 мян.төг


д/д	Авлагын дансдын нэр	2016 он	2017 он	Өсөлт (бууралт)
1	Байгууллагаас авах авлага	199,596.9	149,531.9	(50,065.00)
2	НӨАТ-ын авлага	19,143.7	-	(19,143.70)
3	Хүмүүсээс авах авлага	8,090.6	11,790.0	3,699.40

4	Ажиллагсадтай үүссэн хоолны тооцоо	539.7	469.0	(70.73)
5	Ажиллагсадтай үүссэн урьдчилгааны авлага	1,249.7	3,211.5	1,961.80
6	Найдваргүй авлага	1,651.2	1,651.2	-
Нийт дүн		230,271.8	166,653.6	(63,618.23)

График 1

Авлага насжилтаар

2017 оны жилийн эцсийн авлагыг насжилтаар нь авч үзэхэд 75.8 хувь нь хугацаандаа төлөгдөөгүй авлага байна.



Авлагын ажил гүйлгээтэй холбоотой дараах алдаа, зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд 4 байгууллага, иргэнд 14,953.0 мянган төгрөгийг ямар нэгэн баримтгүйгээр шилжүүлж үндэслэлгүй авлага үүсгэсэн боловч тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Үүнд:
 - Н.Батгэрэлд 3,008.0 мянган төгрөг,
 - Улиастай ван Аудит ХХК-д сэлбэгийн үнэ 2,745.0 мянган төгрөг,
 - Сэлэнгэ ЭТМО ХХК-д моторын үнэ 6,700.0 мянган төгрөг,
 - Х.Сонингэрэлд 2,500.0 мянган төгрөгийг шилжүүлж, тооцоог Топ Инженеринг ХХК-ийн тооцоо руу дамжуулан хаасан.
2. 2005-2016 онуудад 6 байгууллагад 10,656.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн ч өнөөг хүртэл барагдуулаагүй, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна. Үүнд:
 - Булган АЗЗА ТӨХК-тай 2005 онд үүссэн 1,800.0 мянган төгрөгийн,
 - Эм Жи Би И ХХК-тай 2011 онд үүссэн 1,925.0 мянган төгрөг,
 - Мегастракчер ХХК-тай 2015 онд үүссэн 6,328.1 мянган төгрөгийн,
 - Мон өртөөчин ХХК-тай 2016 онд үүссэн 300.0 мянган төгрөгийн,
 - Скайнет ХХК-тай 2016 онд үүссэн 185.0 мянган төгрөгийн,
 - Сэлэнгэ эрчим хүч ХХК-тай үүссэн 118.3 мянган төгрөгийн.
3. Ажиллагсадтай болон хувь хүмүүстэй холбоотой, тухай бүр тооцоо нийлж барагдуулах боломжтой 15,470.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байгаа нь төрийн өмч, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, найдваргүй авлага нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.
4. Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахдаа харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж хэвшээгүй бөгөөд 2017 онд 13 байгууллагатай үүссэн 27,999.3 мянган төгрөгийн, 13 хувь хүнтэй үүссэн 11,057.7 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь уг авлагууд бодитоор оршин буй эсэхийг нотолж чадахгүй байна.
5. 2017 онд касст бэлнээр 373,519.5 мянган төгрөг авч зарцуулсан ч албан томилолтын зардлаас бусад зардалд батлагдсан маягтын дагуу мөнгөн

урьдчилгааны тайлангийн тооцоог /дараа тайлангийн тооцоо/ хийж хэвшээгүй байна.

6. 2005 оноос үүссэн 4 ажлын 54,058.5 мянган төгрөгийн борлуулалтын авлагыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, шүүхийн шийдвэр гаргуулалгүйгээр “Борлуулалтын буцаалт”-аар бүртгэн орлого бууруулан тайлагнасан байна. Үүнд:

- Дархан-Уул аймгийн 0.87 км асфальт бетон зам засвар, арчлалтын 3,374.7 мянган төгрөгийн,
- Аймгийн нэгдсэн эмнэлгийн зам засвар, арчлалтын 20,000.0 мянган төгрөгийн,
- Сүхбаатар сум доторх гурвалжингийн зам засварын 30,000.0 мянган төгрөгийн,
- Улсын төсвийн санхүүжилтийн 683.7 мянган төгрөгийн авлагыг тус тус борлуулалтын буцаалтаар хаасан байна.

Богино хугацаат өр төлбөрийн талаар:

2017 оны эцэст тайлагнагдсан богино хугацаат өр төлбөрийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.9 хувиар буюу 156,142.2 мянган төгрөгөөр буурснаас урьдчилж орсон орлого 225,598.3 мянган төгрөгөөр буурч, бусад өглөг 69,456.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5 / мян.төг /

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өсөлт (бууралт)
Байгууллагад төлөх өглөг	65,374.90	55,835.00	(9,539.90)
Хүмүүст төлөх өглөг	6385.8	1,768.80	(4,617.00)
ХХОАТ-ын өглөг	19,414.70	21,068.60	1,653.90
Орлогын татварын өглөг	565.9	13,343.70	12,777.80
НӨАТ-ын өглөг	40,960.40	86,780.10	45,819.70
Цалингийн өглөг	225	886.4	661.40
НДШ-ийн өглөг		23,416.50	23,416.50
ҮЭХ-ны өглөг	4,904.00	4,187.70	(716.30)
Урьдчилж орсон орлого /тендер/	263,470.30	37,872.00	(225,598.30)
Нийт дүн	401,301.00	245,158.80	(156,142.20)

Бусад өглөгийн өсөлтөд тайлант онд барагдуулах боломжтой байсан НӨАТ-ын, орлогын албан татварын болон НДШ-ийн өглөгүүдийг нэмж үүсгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Жилийн эцэст 10 байгууллагатай холбоотой үүссэн 27,659.7 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг, 2 хувь хүнтэй үүссэн 1,768.8 мянган төгрөгийн хүмүүст төлөх өглөгийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Урт хугацаат өр төлбөрийн талаар:

Төрийн өмчийн хорооны 2009 оны 3/1538 дугаар албан бичгийн дагуу 325,147.9 мянган төгрөгийн техник, хэрэгслийг орлого авч “Төр засгийн үйлчилгээний алба”-д өглөг үүсгэн, урт хугацаат өр төлбөрөөр бүртгэн, тайлагнасан байна.

Гэвч тус өглөгийг барагдуулах хугацаа тодорхойгүй, тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс энэ өглөг бодитой эсэх, хэзээ, хэрхэн барагдуулах нь тодорхой бус байна.

Авлага, өр төлбөрийг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Аудитын явцад өр төлбөр, авлагыг бууруулах, барагдуулах чиглэлээр авч буй арга хэмжээний талаар судалж, холбогдох албан тушаалтнуудаас тодруулга авахад 2017 онд гэрээгээр хуулийн зөвлөх ажиллуулан 2011 оноос үүссэн 3 байгууллагатай холбоотой нийт 104,933.5 мянган төгрөгийн авлагыг /Өсөх урам ХХК-ийн 20,124.2 мянган төгрөгийн, Монголын хурдны зам ХХК-ийн 8,000.0 мянган төгрөгийн, Пи Си Эф ХХК-ийн 76,809.3 мянган төгрөгийн/ барагдуулахаар хуулийн байгууллагад ханджээ.

Дээрхээс бусад авлага, өр төлбөрийг бууруулах, барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч, хэрэгжүүлээгүй байна.

Тайлант хугацаанд тухай бүр тооцоо хийж, барагдуулах боломжтой ажиллагсад болон хувь хүмүүстэй холбоотой 15,470.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн бол мөнгөн хөрөнгийн 527,366.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй атал татвар, нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн 149,683.0 мянган төгрөгийн өглөгийг төлж барагдуулаагүй буюу холбогдох албан тушаалтны хариуцлагагүй үйл ажиллагаанаас дээрх авлага, өр төлбөр тайлагнагдсан байна.

Бүлэг 2

Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу

Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль, журмыг мөрдөөгүй байна.

Оршил

Сэлэнгэ АЗЗА ТӨХК нь 2017 онд 1,097,354.1 мянган төгрөгийн бараа, материал худалдан авч, 982,834.2 мянган төгрөгийн материалыг зарцуулан, 240,823.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан бол 78,700.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Хүснэгт 6

Үзүүлэлтүүд	Бараа материал /мян.төг/	Үндсэн хөрөнгө /мян.төг/
Эхний үлдэгдэл	126,303.1	1,920,576.7
Нэмэгдсэн	1,097,354.1	78,700.0
Хасагдсан	982,834.2	
Эцсийн үлдэгдэл	240,823.1	1,999,276.7

2.1 Тайлант онд 11 төрлийн бараа, ажил, үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас 8-д нь зохион байгуулаагүй байна.

Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн “2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах” тухай 05 дугаар тогтоолоор 3 төрлийн нийт 756,888.1 мянган төгрөгийн /115,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн, 287,888.1 мянган төгрөгийн шатах, тослох материал, 354,000.0 мянган төгрөгийн битум/ хөрөнгө, материал авахаар баталсан байна.

Гэвч тайлант онд Засгийн газрын 2013 оны 68-р тогтоолоор баталсан шууд худалдан авах босго үнэ болох 10,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10 төрлийн 930,671.5 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэжээ.

Үүнээс үндсэн хөрөнгө, шатахуун, түлш, шатах тослох материал, битум худалдан авах 604,610.4 мянган төгрөгийн худалдан авалтад худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бол дараах 326,061.1 мянган төгрөгийн худалдан авалтыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулаагүй бөгөөд холбогдох хууль, журмыг зөрчсөн байна. Үүнд:

1.Сэлэнгэ АЗЗА ТӨХК нь улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн 3 зам засвар, арчлалтын ажлыг туслан гүйцэтгэгчгүйгээр гүйцэтгэхээр тендерт шалгарч, захиалагч байгууллагуудтай гэрээ байгуулсан ч ТБОНӨХБАУХА тухай хуулийг² зөрчин туслан гүйцэтгэгчээр ажиллуулах гэрээ байгуулж, 3 компанид нийт 229,277.2 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Үүнд:

- Дархан-Уул аймгийн стадиноос Хараа голын гүүр хүртэлх зам шинэчлэлтийн 787,881.5 мянган төгрөгийн өртөгтэй ажлаас ЭНУ хүрэл ХХК-иар “2 цэгт төмөрбетон хоолой бариулахаар туслан гүйцэтгэгчийн гэрээ” байгуулан, 168,963,0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Гэвч уг ажлын төсөвт өртгийг хяналтын зураг төсвөөр баталгаажуулаагүй, ажлын гүйцэтгэлийг гаргуулж хяналт тавиагүй байна. Уг ажилд нэмж 13,314.2 мянган төгрөгийн магадалшгүй ажлын зардал гарсныг төсөв хийж баталгаажуулсан ч ажлын гүйцэтгэлийг гаргаж баталгаажуулаагүй байна.
- Сэлэнгэ аймгийн Партизаны талбайн зам засварын 241,366.4 мянган төгрөгийн ажлаас Сэлэнгэ таван хан ХХК-тай “гэрэлтүүлгийн ажил гүйцэтгүүлэх туслан гүйцэтгэгчийн гэрээ” байгуулж, 40,000 мянган төгрөг шилжүүлсэн байна.
- Дулаанхан тосгоны төв зам дагуу явган хүний зам засварын 7,000.0 мянган төгрөгийн ажлыг Болор сан ХХК-иар гүйцэтгүүлсэн байна.

2. Дараах 4 төрлийн 96,783.9 мянган төгрөгийн худалдан авалтад ТБОНӨХБАУХА тухай хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан худалдан авах ажиллагааны босго үнийн журмыг мөрдөөгүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Хүснэгт 7

д/д	Худалдан авсан барааны нэр	Худалдан авалтын жилийн дүн /мян.төг/	Бэлтгэн нийлүүлэгч байгууллага
1	АЗХ хөрөөний ир	10,400.0	Топ инженеринг ХХК
2	Автогрейдэрийн хутганы ир	24,000.0	Халиун уул ХХК, Эм эн би эс ХХК
3	Замын хашлага	49,283.9	Мөнх-Од цацрал ХХК
4	Замын цагаан будаг	13,100.0	Хараа сүмбэр ХХК
	Нийт дүн	96,783.9	

Өөрөөр хэлбэл тус компани нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгээгүй байна.

2.2 Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 1,9 дахин, үүний дотор сэлбэг хэрэгсэл 2,9 дахин, барилгын материал 1,5 дахин өссөн бол өмнөх онд үлдэгдэлгүй байсан бараа, бэлэн бүтээгдэхүүн тайлант оны эцэст 57,439.4 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Компанийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад байнгын хяналт тавих “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг тус компанийн гүйцэтгэх захирлын 2015 оны Б/08 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

² 41 дүгээр зүйл.Худалдан авах гэрээнд нэмэлт, өөрчлөлт хийхийг хориглох: 41.2.Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Гэвч уг зөвлөл нь үйл ажиллагаа явуулж хэвшээгүй бөгөөд захирлын зөвлөлөөс өмч хөрөнгийг бэлтгэх, актлах хөрөнгийн шийдвэрийг гаргаж, техникийн комиссын актыг баталгаажуулж ирсэн байна.

Тайлант онд 1,097,354.1 мянган төгрөгийн бараа материалын орлого авч 982,834.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулан, 240,823.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан бол 78,700.0 мянган төгрөгийн уур үүсгэгч тогоо, асфальт индүүдэгч худалдан авснаар 1,999,276.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын нийт үлдэгдэл 2017 оны эцэст өмнөх оныхоос 1,9 дахин, үүний дотор сэлбэг хэрэгсэл 2,9 дахин, барилгын материал 1,5 дахин өссөн бол өмнөх онд үлдэгдэлгүй байсан бараа, бэлэн бүтээгдэхүүн тайлант оны эцэст 57,439.4 мянган төгрөгөөр тайлагнагджээ.

Ингэж бараа, материалын үлдэгдэл хэт нэмэгдсэн байгаа нь хэрэгцээнээс илүү бараа, материал нийлүүлэгдэж, хөрөнгийн эргэлтийг удаашруулах, бэлэн мөнгөний дутагдалд орох эрсдэлийг дагуулахаас гадна хөрөнгийн бэлтгэн нийлүүлэлт, зарцуулалтад “Өмч хамгаалах зөвлөл”-ийн хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 8 /мян.төг /

Бараа, материалын хөдлөл, өөрчлөлт

д/д	Бараа материалын нэр дансдаар	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	ААМатериал	167.80	3,597.10	3,502.00	262.90
2	Бараа, бэлэн бүтээгдэхүүн		315,681.40	258,242.00	57,439.40
3	Хангамжийн материал	3,405.70	15,004.80	16,908.20	1,502.30
4	Ашиглалтад байгаа хангамжийн материал	67,504.60	9,955.00	3,676.60	73,783.00
5	Барилгын материал	27,127.20	387,514.90	373,652.50	40,989.60
6	Сэлбэг хэрэгсэл	19,706.70	100,593.10	62,486.90	57,812.90
7	Шатах тослох материал	1,692.10	41,622.20	42,383.40	930.90
8	Шатахуун		215,861.40	215,861.40	-
9	Эргэлтийн мал сүрэг, амьтад	6,699.00	6,265.00	4,862.00	8,102.00
10	Уулын хайрга		1,259.20	1,259.20	
	Нийт дүн	126,303.10	1,097,354.10	982,834.20	240,823.00

Бараа материалын хөдлөл, өөрчлөлтөөс харахад хангамжийн материал, сэлбэг хэрэгсэл, мал амьтад болон борлуулахаар хүлээгдэж байгаа бэлэн бүтээгдэхүүн нь нийт бараа материалын үлдэгдлийн 59.0 хувийг эзэлж байгаа бол 41.0 хувийг барилгын материал, сэлбэг хэрэгсэл гэсэн 2 төрлийн бараа материал эзэлж байна.

Барилгын материалын болон сэлбэг хэрэгслийн үлдэгдэл нэмэгдсэн нь дараах бараа материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9 /мян.төг /

д/д	Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
Сэлбэг хэрэгсэл					
1	□□□□□□□□□□	-	9,724.5	270.0	9,454.5
2	□□□□□□□□□□□□□□□□	3,181.8	8,727.3	3,181.8	8,727.3
3	GR-135 □□□□□□□□□□□□□□□□	-	6,000.0	-	6,000.0
4	н □у □□□□500	-	4,545.5	-	4,545.5
5	□□□□□□□□□□□□□□□□	-	4,490.9	1,209.1	3,281.8
6	□□□□□□□□□□□□□□	-	1,309.1	-	1,309.1
7	□□□□□□□□□□□□□□□□	-	8,727.3	7,418.2	1,309.1
8	□□□□□ □□у □□□ у АА□	-	1,727.3	535.5	1,191.8

9	с	-	1,000.0	-	1,000.0
10		-	2,127.3	1,418.2	709.1
Барилгын материал					
11	90/130		16,437.3	9,280.9	7,156.4
12		222.0	4,501.4	1,405.7	3,317.7
13		-	11,774.7	8,574.7	3,200.0
14		-	44,803.6	42,076.4	2,727.3
15	803	-	1,956.8	5.5	1,951.4
16	2mp PTZ	-	760.0	-	760.0
17		600.0	500.0	600.0	500.0
Нийт дүн		4,003.8	129,113.0	75,975.9	57,140.9

Сэлэнгэ АЗЗА ТӨХК нь ашиглалтгүй үндсэн хөрөнгийн судалгааг гаргаж хэрэгцээ, шаардлага хангахгүй, ашиглагдахгүй болсон 39 төрлийн 158,282.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлуулах санал оруулахаар бэлтгэсэн бол ашиглалтгүй, бараа материал, түүний шалтгааны судалгааг гаргаагүй байна.

Он дамжин зарцуулагдаагүй барилгын материалын дансанд бүртгэлтэй 31 төрлийн 7,304.9 мянган төгрөгийн, сэлбэг хэрэгслийн дансанд бүртгэлтэй 87 төрлийн 2,564.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байгаад дүн шинжилгээ хийж, ашиглалтгүй, ашиглагдахгүй болсон бараа материалын судалгааг гаргаж, шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2.3 Хөрөнгийн тооллогын комиссоос дутагдсан хөрөнгийг нөхөн барагдуулахаар санал оруулсныг хэрэгжүүлээгүй байна.

Сэлэнгэ АЗЗА ТӨХК нь тайлант онд 34,720.0 мянган төгрөгийн хоол, хүнсний материал, 1,249.7 мянган төгрөгийн малын эм, галын түлээ зэрэг бараа материалыг бараа материалын тайланд орлого авалгүй, шууд зардлаар бүртгэсэн байсныг 2018 онд залруулсан байна. Үүнээс бусад хөрөнгө, материалыг тухай бүр орлого авч, зарцуулан бүртгэлд тусгаж, үлдэгдлийг тус компанийн захирлын тушаалаар томилогдсон тооллогын комисс тоолж, баталгаажуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын 2017 оны эхний хагас жилийн тооллогыг компанийн захирлын А/15 дугаар тушаалаар томилогдсон 6 хүний бүрэлдэхүүнтэй комисс, жилийн эцсийн тооллогыг А/34 дүгээр тушаалаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс тус тус тоолж, баталгаажуулсан байна.

Тооллогоор нийт 2,245,963.3 мянган төгрөгийн хөрөнгө тоолсноос 288,247.2 мянган төгрөгийн барилга байгууламж, 40,240.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 447,817.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 453,668.5 мянган төгрөгийн авто машин, 769,303.2 мянган төгрөгийн механизмын, 240,823.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл тоологдсон байна.

Тооллогын дүнд 5 ажилтантай холбоотой хөрөнгийн дутагдал илэрснийг шийдвэрлүүлэхээр удирдлагад санал оруулсан ч хөрөнгийг нөхөн төлүүлж, тооцоо хийгээгүй байна. Үүнд:

1. Гүйцэтгэх захирлын картад бүртгэлтэй 45.0 мянган төгрөгийн чихрийн таваг,
2. Ерөнхий нягтлан бодогчийн картад бүртгэлтэй 1,500.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг,
3. Дутагдсан 8 малд дүгнэлт гаргаж, акт үйлдээгүй,
4. Авто гражийн эрхлэгчийн картад бүртгэлтэй 150.0 мянган төгрөгийн кабиныг зарж борлуулан, мөнгийг тушаасан ч данснаас хасаагүй байна.

Бүлэг 3

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй байна уу

Бусад байгууллагаас дотоод хяналт шалгалт хийж алдаа, зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлж байгаа ч хэрэгжилт хангалтгүй, үр нөлөө бага байна.

Оршил

Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн дүрмийн 10 дугаар бүлэгт дотоод хяналтын тогтолцоог дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

10.1 Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

10.1.1 Өмчлөгчийн хяналт;

10.1.2 Дотоод хяналт;

10.1.3 Хөндлөнгийн аудит;

“Өмчлөгчийн хяналт”-ыг ТУЗ-ийн дэргэдэх “Аудитын хороо”, “Дотоод хяналт”-ыг компанийн Гүйцэтгэх захирлын томилсон “Дотоод хяналтын алба”, “Хөндлөнгийн аудит”-ыг компанийн ТУЗ-өөс сонгосон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллага тус тус хэрэгжүүлэхээр заасан байна.

3.1 ТУЗ-өөр компанийн санхүүгийн тайлан, үр дүнг хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгч байгаа боловч нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн зарцуулалт, худалдан авах ажиллагаанд явцын хяналт, шалгалт хийгдээгүй байна.

2017 онд ТӨХ-ны бодлого зохицуулалтын газрын 2 удаагийн тогтоолоор Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн 2 гишүүнд өөрчлөлт оруулснаар 2017 онд 9 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, тэдний цалинд 24,880.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 3,270.9 мянган төгрөг, бусад зардалд 926.3 мянган төгрөг зэрэг нийт 29,077.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.41-д **“ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно;”** гэж заасан ч 2017 онд сар бүр бус 4, 6, 11 саруудад 3 удаа хуралдаж, 12 тогтоол шийдвэр гаргасан байна.

ТУЗ-ийн 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 10 дугаар тогтоолоор компанийн гүйцэтгэх захиралтай 2017/СЭ-01 дугаартай гэрээ байгуулж, 2018 оны 03 дугаар тогтоолоор компанийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний биелэлтийг **“Хангалттай”** гэж дүгнэсэн байна.

Сэлэнгэ-АЗЗА ТӨХК нь 2017 оны үйл ажиллагааны үр дүнгээр 106,847.2 мянган төгрөгийн ашиг хүртсэн боловч орлого, зарлагыг өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн бодитоор төлөвлөөгүй, хөрөнгө, эх үүсвэрийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ гүйцэтгэсэн зэрэг санхүү, бүртгэлийн зөрчилтэй ажиллаж байхад ТУЗ-ийн зүгээс ямар нэгэн хяналт, шалгалт хийж, заавар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Өөрөөр хэлбэл тус компанийн санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна.

3.2 Компанийн дүрэмд заасан дотоод хяналтын тогтолцоо төлөвшөөгүй, бусад байгууллагаас хийсэн дотоод хяналт шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалтад *“Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.”* гэж заасан боловч өнөөг хүртэл “Дотоод хяналтын алба”-ыг томилж ажиллуулаагүй байна.

Харин 2017 онд *“Санхүүч, дотоод үйл ажиллагааны хяналтын ажилтан”*-ы орон тоог батлуулж, 7 дугаар сараас эхлэн ажиллуулсан боловч уг ажилтан нь ямар ажил хийх нь тодорхойгүй, хийх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх баримт бичгүүд байхгүй байна.

Өөрөөр хэлбэл тус компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үйл ажиллагаа төлөвшиж, хэрэгжээгүй байна.

Бусад байгууллагаас хийсэн дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2014, 2017 онуудад, татвар ногдуулалт, барагдуулалтын үйл ажиллагаанд аймгийн Татварын хэлтсээс 2016 онд тус тус хяналт шалгалт хийсэн байна.

ТӨБЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу *“Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн 2015-2016 оны санхүү, эдийн засаг, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалт, удирдлагын үйл ажиллагаа”*-д хяналт, шалгалт хийж, нийт 853.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг арилгуулахаар 6 зөвлөмж өгснөөс *“бүтээгдэхүүн арчлалт үйлчилгээний өртгийн тооцоололт, зардлын хуваарилалтад анхаарч ажиллах, хугацаа хэтэрсэн 97.6 сая төгрөгийн авлагыг шүүхэд шилжүүлэх”* гэсэн 2 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Харин дараах 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулаагүйгээс алдаа, зөрчил давтагдан гарсаар байна. Үүнд:

- *Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллах, төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил, үйлчилгээ, зардлыг санхүүжүүлэхгүй байх,*
- *Мөнгөн кассын үйл ажиллагаанд баримтлах журмын боловсруулалтыг сайжруулах, мөрдөн ажиллах,*
- *Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулах, худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөн ажиллах,*
- *Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.*

Төрийн өмчийн хорооны 2014 оны хяналт, шалгалтаар тус компанийн 2012, 2013, 2014 оны эхний хагас жилийн санхүү, эдийн засаг, үйлдвэрлэл, удирдлагын үйл ажиллагаанд шалгалт хийж 422,765.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг арилгуулахаар 9 зөвлөмж өгсөн ч хэрэгжилтийн тайлан, мэдээ гаргаагүй байна.

Аймгийн Татварын хэлтсээс 2016 онд 2013-2015 оныг дуусталх хугацааны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, 2,994.4 мянган төгрөгийн татвар,

898.3 мянган төгрөгийн торгууль, 1,442.0 мянган төгрөгийн алданги зэрэг нийт 5,334.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан байна.

Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны орлого, зарлагыг бодит байдалд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүй байна.
2. Ажил гүйлгээг дэмжих анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, борлуулалтын орлогын журнал хөтлөөгүй зэргээс шалтгаалан санхүүгийн тайланд орлого дутуу илэрхийлсэн байна.
3. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл, тайланд тусгасан зөрчил нийтлэг байдлаар оршиж байна.
4. Хөрөнгө нөөцийг зохистой удирдаагүйгээс үүсэхгүй байх боломжтой авлага, өр төлбөр үүсгэсэн бөгөөд авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
5. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль, журмыг мөрдөөгүй байна.
6. Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн зам засвар, арчлалтын ажлуудыг өөрийн хүчээр гүйцэтгэхээр тендерт шалгарсан боловч гүйцэтгэлийн явцад туслан гүйцэтгэгч ажиллуулсан байна.
7. Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 1,9 дахин, үүний дотор сэлбэг хэрэгсэл 2,9 дахин, барилгын материал 1,5 дахин өссөн байна.
8. Тус компанийн санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ болон холбогдох байгууллагуудаас тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Илэрсэн зөрчил

Хийж гүйцэтгэсэн аудитын дүнгээр нийт **621,514.8 мянган төгрөгийн** алдаа, зөрчил илэрснээс **2,693.2 мянган төгрөгийн** зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, **618,821.6 мянган төгрөгийн** зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Акт:

Зориулалт тодорхойгүй, анхан шатны баримтгүй дараах 2,693.2 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээр нөхөн төлүүлэх. Үүнд:

- Солонго инвест ХХК-иас анхан шатны баримтгүйгээр архи худалдан авсан 148.0 мянган төгрөг,
- Анхан шатны баримтгүйгээр шатахуун худалдан авсан 39,4 мянган төгрөг, цэцэг худалдан авсан 12.0 мянган төгрөг, хоол авсан 134.5 мянган төгрөг,
- Томилолтын үнэмлэх, дагалдах баримтгүйгээр 9 ажилтанд олгосон 1,478.0 мянган төгрөг,
- Албан томилолтыг илүү бодож олгосон 301.5 мянган төгрөг,
- Иргэн Х.Ариунжаргалд илүү шилжүүлсэн 579.8 мянган төгрөг зэрэг болно.

2. Албан шаардлага:

Нийт 618,821.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага бичигдэв. Үүнд:

- 1 *Тайлант хугацаанд 3 ажлын нийт 72,742.6 мянган төгрөгийн орлогыг бүртгэл, тайланд тусгаагүй,*
- 2 *Гэрээний дагуу бусдаар гүйцэтгүүлсэн ажлыг актаар хүлээн аваагүй, харилцагч байгууллагын орлогын ордергүйгээр кассаас зарлага гаргасан, нэхэмжлэх, бэлэн мөнгө хүссэн өргөдөлгүйгээр болон харилцагчийн нэр зөрүүтэй шилжүүлэг хийсэн зэргээр анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 97,473.9 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийсэн,*
- 3 *Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахдаа харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж үлдээдлийг баталгаажуулалгүйгээр 39,057.0 мянган төгрөгийн авлага, 29,428.5 мянган төгрөгийн өглөг тайлагнасан, үүнээс 4 байгууллага, иргэнд 14,953.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр шилжүүлэн авлага үүсгэсэн,*
- 4 *Холбогдох байгууллагын шийдвэргүйгээр 2005 оноос үүссэн 3 ажлын 54,058.5 мянган төгрөгийн авлагыг 2017 оны борлуулалтын орлогыг бууруулан борлуулалтын буцаалтаар хаан, данснаас хассан,*
- 5 *Улс, орон нутгийн төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн 3 ажилд холбогдох хууль, тогтоомжийг зөрчин туслан гүйцэтгэгч ажиллуулан 229,277.2 мянган төгрөг шилжүүлсэн,*
- 6 *Тайлант онд нийт 4 төрлийн 96,783.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтад зохих хууль, журмыг мөрдөөгүй.*

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Гүйцэтгэх захирал Л.Ганболдод:

1. Үйл ажиллагааны орлого, зарлагыг бодит байдалд үндэслэн үнэн зөв төлөвлөх, батлагдсан төлөвлөгөөний хүрээнд зардал гаргах, шаардлагатай тохиолдолд ТУЗ-өөр тодотгол хийлгүүлж байх.
2. Хөрөнгө нөөцийг зохистой удирдаж, аль болох авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, нэгэнт үүссэн авлага, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах.
3. Холбогдох байгууллагатай тооцоо нийлж, 2009 онд нийлүүлсэн техник хэрэгслийн 325,147.9 мянган төгрөгийн өр төлбөрийг төлөх эсэх асуудлыг шийдвэрлэх.
4. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах.
5. Тооллогын дүнгээр 5 ажилтантай холбоотой илэрсэн хөрөнгийн дутагдлыг нөхөн төлүүлэх, тооллогын комиссын дүгнэлт, шийдвэрийг хэрэгжүүлж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, залруулж байх.
6. Компанийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтад байнгын хяналт тавих “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг шинэчлэн баталж, үйл ажиллагааг идэвхжүүлэх.
7. Компанийн дүрэмд заасны дагуу санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх захирлын зүгээс тавих дотоод хяналтыг сайжруулах.
8. Холбогдох байгууллагуудаас хийсэн хяналт шалгалтын мөрөөр хийх ажлын төлөвлөгөө гаргаж, гүйцэтгэлийг тайлагнаж байх.
9. Аудитын тайланг компанийн ТУЗ-д хүргүүлж, танилцуулах.

Ерөнхий нягтлан бодогч Х.Ганбаатарт:

1. Нягтлан бодох бүртгэлийг НББОУС-ын дагуу хөтөлж, борлуулалтын орлогыг бүртгэл тайланд бүрэн тусгаж байх.
2. Бэлэн мөнгөөр хийгдэж байгаа дараа тайлангийн тооцоог холбогдох заавар, маягтын дагуу гаргаж байх.
3. Харилцагч байгууллагын нэхэмжлэх, бэлэн мөнгөний орлогын ордер, томилолтын хуудас, ажил хүлээн авсан акт зэрэг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтуудыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх.
4. Авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, ажиллагсадтай үүссэн богино хугацаат авлага, өр төлбөрийг санхүүгийн жилд багтаан барагдуулж байх.
5. Холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй худалдан авах ажиллагааг санхүүжүүлэхгүй байх.

Сэлэнгэ АЗЗА ТӨХК-иас ирүүлсэн санал, тайлбар



“СЭЛЭНГЭ АВТО ЗАМ ЗАСВАР АРЧЛАЛТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

213200 Сүхбаатар, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: 7036-3889

2018. 10. 09 № 324
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар гаргах тухай

2018 оны 09 сарын 25 ны өдрийн албан бичгийн дагуу манай компанийн 2017 оны санхүүгийн зарим үйл ажиллагааны үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын төсөлд тайлбар гаргах нь:

1. Бизнес төлөвлөгөөний борлуулалтын болон бусад орлогыг тооцоолж батлуулаагүй 115,486.5 мянган төгрөгийн алдааг 2018 оноос зорилтот түвшингийн маягт өөрчлөгдөж залруулагдсан.
2. УБТЗ нийгэмлэгийн Барилга ашиглалт, үйлчилгээний 2-р ангитай байгуулсан 5,485.0 мянган төгрөгийн 32 айлын орон сууцны барилгын гадна дулааны ажлын дараах асфальтан замыг сэргээх ажлыг, Цагааннуур сумын Засаг даргын орлогчтой байгуулсан 8,000.0 мянган төгрөгийн хогийн нэгдсэн цэгийн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг, Сэлэнгэ аймгийн Засаг даргатай байгуулсан 231,113.2 мянган төгрөгийн Сүхбаатар сумын Партизаны талбайн зам, авто зогсоол байгуулах ажлын 59,257.6 мянган төгрөгийн орлогын УБТЗ нийгэмлэгийн 5,485.0 мянган төгрөгийн орлогыг авлага үүсгэж энэ ондоо барагдуулна. Цагааннуур сумын 8,000.0, Сэлэнгэ аймгийн 59,257.6 мянган төгрөгийн орлогыг 2018 оны 03-р улирлаар борлуулалтанд тусгаж оруулсан.
3. Борлуулалтын журнал 2018 оноос хөтөлж хэвшинэ.
4. МТЧ ХХК болон Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ-тай гэрээ нөхөж байгуулан гэрээ дүгнэсэн акт үйлдсэн.
5. Ерөө сумын дотор зам засварын 19,280.0 төгрөгийн ажлыг бөөн дүнгээр хүлээлгэн өгч акт үйлдсэн. БТСГ-тай гэрээ дүгнэсэн актыг нөхөж үйлдсэн.
6. Кассын орлогын дагалдах 2,324.5 мянган төгрөгийн баримтыг нөхөж үйлдэж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.
7. 2018 оны зорилтот түвшинд зардлын төлөвлөгөөг төрөл нэмж залруулагдсан.
8. Касс харилцахад анхан шатны баримтанд 15,594.4 мянган төгрөгийн баримт бүрдүүлж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.
9. Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын 2,704.5 мянган төгрөгийн гэрээ дүгнэсэн актыг бүрдүүлсэн.

10. Харилцагчын тооцоог төлөхдөө харилцагч байгууллагын орлогын ордер 2,100.0 мянган төгрөгийн баримт нөхсөн. Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.
11. Харилцагч байгууллагын данс руу төлбөрийг шилжүүлж тооцоо нийлж ажиллана.
12. Ачаа тээврийн гэрээг нөхөж хийн гэрээ дүгнэсэн акт үйлдсэн.
13. Албан томилолтын зардлыг буудал болон замын зардлаар тооцож зардалд хааж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.
14. Анхан шатны баримтгүй гүйлгээг цаашид бүртгэлд тусгахгүй байна.
15. Пи Си Эф ХХК – 76.8 сая, Өсөх Урам ХХК - 20.1 сая. Монголын Хурдны Зам ХХК 8.0 сая төгрөгийн авлага шүүхийн зарчмаар явж байгаа.
16. 54,058.5 төгрөгийн борлуулалтын буцаалтыг ТУЗ-өөр хэлэлцүүлж зөвшөөрөл авснаар авлага хаана.
17. Татварын 121,192.5, НДШ-ийн 24,416.5, Харилцагчдын 27,175.2 мянган төгрөгийн өглөгийн тооцоо нийлж акт үйлдсэн.

Битум нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж Саус Гоби Сэндс ХХК шалгарсан боловч битум нийлүүлж чадахгүй гэснээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ авах тухай хуулийн 34.1.5–д заасан гэнэтийн болон хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол;" гэж заасны дагуу шууд гэрээ байгуулсан.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л.ГАНБОЛД

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар

Тус компанийн 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 324 дүгээр албан бичгээр ирүүлсэн тайлбар болон тайлангийн төслийн хугацаанд нөхөж ирүүлсэн баримт, материалд үндэслэн дараах алдаа, зөрчлийг залруулсан гэж үзэн тайланд өөрчлөлт хийв. Үүнд:

Төлбөрийн актыг залруулж, зөрчлийн дүнгээс хассан:

1. УБТЗ нийгэмлэгийн Барилга ашиглалт, үйлчилгээний 2-р ангиас авах 5,485.0 мянган төгрөгийн зам засварын ажил үйлчилгээний орлогыг бүртгэлд тусгаагүй, авлага үүсгээгүй байсныг аудитын явцад тооцоо нийлж баталгаажуулан, 2018 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд авлагаар тусгуулсан учир залруулсан гэж үзэв.
2. Мегалайн ХХК-д 7,000.0 мянган төгрөгийн, Эко вейст ХХК-д 3,500.0 мянган төгрөгийн хайрга, дайрга, элс тээвэрлүүлсэн ажлын хөлсний гэрээ, актыг төслийн хугацаанд нөхөн ирүүлж, баримтад хавсаргасан учир залруулсан гэж үзэв.
3. Буудлын 890,0 мянган төгрөгийн, гадаад томилолтын 1,567.6 мянган төгрөгийн зардлын баримтыг тайлангийн төслийн хугацаанд нөхөн ирүүлж, баримтад хавсаргасан учир залруулсан гэж үзэв.

Албан шаардлагын дүнгээс хассан:

1. 115,486.5 мянган төгрөгийн орлогыг, 297,877.0 мянган төгрөгийн зайлшгүй гарах зардлыг төлөвлөөгүй байсныг 2018 оноос зорилтот түвшний маягт шинэчлэгдсэнтэй холбоотойгоор орлого, зарлагыг дэлгэрэнгүй байдлаар төлөвлөж байгаа тул залруулсан гэж үзэв.
2. 40,071.5 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг нотлох анхан шатны баримтыг тайлангийн төслийн хугацаанд нөхөн үзүүлж, баримтад хавсаргасан тул залруулсан гэж үзэв.
3. Харилцагчийн орлогын ордер, нэхэмжлэх, бэлэн мөнгө хүссэн өргөдөлгүй зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйцэтгэсэн 134,752.3 мянган төгрөгийн гүйлгээний холбогдох баримтуудыг тайлангийн төслийн хугацаанд нөхөн үзүүлж, баримтад хавсаргасан тул залруулсан гэж тооцов.
4. 2017 оны эцэст тайлагнагдсан 118,532.6 мянган төгрөгийн авлага, 172,784.2 мянган төгрөгийн өглөгийн тооцоо нийлсэн актуудыг аудитын явцад нөхөн үзүүлж, баримтад хавсаргасан учир залруулсан гэж үзэв.
5. 2017 онд 187,626.7 мянган төгрөгийн битумыг зайлшгүй нөхцөл шаардлагын улмаас шууд худалдан авсан гэсэн тайлбарыг хүлээн авч залруулав.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Б.ЭРДЭНЭЗУЛ
Ц.УРТНАСАН



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/13

Сүхбаатар

Г ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН, Г
ДҮНГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/188 дугаар тушаалын 5-р хавсралт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40, 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторт Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн зарим үйл ажиллагаа"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн нөхөн төлүүлэх төлбөрийн акт, зөрчил арилгуулах албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Ганболдод хүргүүлж, Selenge@audit.gov.mn цахим хуудсаар нийтэд мэдээлсүгэй.

4. Аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Батмөнх/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

0000113

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын
 газрын дарга, дэргүүлэх аудиторын
 2018 оны 10 сарын 12 өдрийн
 13 дугаар тушаалын Хавсралт
 / мянган төгрөгөөр /

№	Төлбөр, зөрчлийн утга	Акт, албан шаардлагын дугаар	Нийт зөрчил 143998 9055436	Акт	Албан шаардлага
1	Анхан шатны баримтгүйгээр болон томилолтын зардлыг тогтоосон хэмжээнээс илүү тооцон олгосон.	СЭА-01/03-ГА	1,779.5	1,779.5	
2	Анхан шатны баримтгүй, буруу тооцооллын улмаас зориулалт бус зардал гаргасан.	СЭЛ-02/04-ГА	913.7	913.7	
3	Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахдаа харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, анхан шатны баримтгүйгээр шилжүүлэг хийж авлага үүсгэсэн.	СЭА-01/14-ГА	68,485.5		68,485.5
4	Борлуулалтын орлого дутуу тусгасан, тайлант хугацааны орлогыг дараа онд шилжүүлэн бүртгэсэн.	СЭА-02/15-ГА	72,742.5		72,742.5
5	Бараа, ажил худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмыг мөрдөөгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлсэн.	СЭА-03/16-ГА	326,061.2		326,061.2
6	2005 оноос хойш үүссэн борлуулалтын авлагыг борлуулалтын буцаалтаар хааж 2017 оны орлогыг бууруулан тайлагнасан.	СЭА-04/17-ГА	54,058.5		54,058.5
7	Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр болон бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, бүртгэлд тусгасан.	СЭА-05/18-ГА	97,473.9		97,473.9
Нийт дүн			621,514.8	2,693.2	618,821.6